

**АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ
2017-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018.12.20

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр			
1	“Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх аймгийн хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 118 дугаар тогтоолоор 9 бүлэг, 5 зорилт бүхий “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг батлуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сум, агентлаг, холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аян болон хяналт шалгалтын удирдамжийг аймгийн Засаг даргын 2017 оны А/412 дугаар захирамжаар батлуулан, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдад хүргүүлэн хэрэгжилтийг хангах ажлыг эхлүүлээд байна.	100
2	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах хүний нөөцийг бүрдүүлэх, давтан сургалт зохион байгуулах	2017-01-05-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан” онлайн сургалтанд хамрагдсан. Аймгийн Татварын хэлтэс, Прокурорын газар, Цагдаагийн газар, Ерөө, Сайхан сумдын нийт ХАСХОМ гаргагч албан тушаалтнуудад ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн цахим системийн шинэчлэл, мэдүүлэг хэрхэн гаргах тухай сэдвүүдээр сургалт хийсэн. Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар бүртгэж, бүрдүүлэлтийн программд шивж оруулсан. Нийт 221 албан тушаалтан хугацаандаа хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн. Орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа 7 ТББ-ын удирдах албан тушаалтны мэдүүлгийг бүртгэж ажилласан. Хугацаа хоцроосон буюу мэдүүлэг гаргахаас татгалзсан мэдүүлэгч гараагүй.	100

3	Сумдын бүсүүдэд авлигын эсрэг сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Аймгийн Татварын хэлтэс, Прокурорын газар, Цагдаагийн газар, Ерөө, Сайхан, Жавхлант, Түшиг, Цагааннуур сумдын нийт ХАСХОМ гаргагч албан тушаалтнуудад ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн цахим системийн шинэчлэл, мэдүүлэг хэрхэн гаргах тухай Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдвүүдээр сургалт хийсэн.	70
4	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр иргэн, төрийн бус байгууллагыг татан оролцуулах	Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	100
5	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах зорилгоор иргэдэд зориулсан ёс зүй, ухамсар сэтгэлгээг өөрчлөх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, явц үр дүнг мэдээлж тайлагнах	Тайлант онд Авлигын хор хөнөөл, аюулыг ухуулан таниулах сургалтыг Сайхан, Ерөө, Жавхлант, Түшиг, Цагааннуур сумдын Засаг даргын Тамгын газрын нийт төрийн албан хаагчид, иргэдэд зохион байгуулан ажилласан.	70
Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр			
6	Байгууллага бүрийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллуулах	2017 онд сум, агентлагийн дарга нарын үр дүнгийн гэрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах заалтуудыг хууль зүйн салбарын ажил, арга хэмжээ гэсэн гэрээний 2 дугаар хавсралтаар мөрдөж ажиллах талаар оруулсанаар байгууллага, сум бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан.	100
7	“Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аяныг зохион байгуулах	“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилго бүхий “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аян болон хяналт, шалгалтын удирдамжийг аймгийн Засаг даргын 2017 оны А/412 дугаар захирамжаар батлуулан энэ оны 10 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна.	100
8	Байгууллага бүр авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан орон тооны	Байгууллага бүр Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр батлагдсанаас хойш буюу 2018 оноос авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	30

	бус зөвлөлтэй болох	сэргийлэх, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлийг байгуулахаар төлөвлөсөн.	
9	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд мэдээлэх	Гадаад орнуудтай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд Япон улсын Шизуока мужтай газар тариалангийн салбарт хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан харилцаа тогтоосноор Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд САГАД будаа тариалж, Япон улсын зах зээлд нийлүүлэхээр бэлтгэл бүрэн хангаж, олон нийтэд мэдээлж ажилласан. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөртэй хамтран “Орон нутгийн цогц хөгжил-түншлэл” төслийг хамтран хэрэгжүүлж, Сэлэнгэ аймгийн төр, иргэний нийгмийн байгууллага, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, уул уурхайн салбар гэсэн 4 талт түншлэлд тулгуурлан хөгжүүлэхээр олон талт төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж, хамтын ажиллагааны талаараа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон аймгийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	100
10	Тухайн байгууллагын чиг үүргийн дагуу олгож буй тусгай зөвшөөрлийн мэдээлэлтэй танилцах боломжоор ханган ажиллах	Аймгийн Засаг даргын Тамгын газраас Архи, согтууруулах ундаа үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын гэсэн 5 төрлийн тусгай зөвшөөрлийг зохих хууль тогтоомжийг баримтлан олгож байна. 2016 онд дээрх ажлын хүрээнд шинээр 3 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл олгож, 44 аж ахуйн нэгж, байгууллагын зөвшөөрлийн хугацааг сунгах үйлчилгээг үзүүлсэн байна. 2017 онд дээрх ажлын хүрээнд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийн сунгалтыг 33 аж ахуйн нэгжид хийж, 6 аж ахуйн нэгжид шинээр, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын 37, ашиглалтын 1 тусгай зөвшөөрлийг тус тус олгон ажилласан.	100
11	Төрийн албаны сонгон шалгаруулалт явуулах асуудлыг олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах	Төрийн албаны хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн талаарх төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний талаарх мэдээлэл авах боломжоор хангах үүднээс аймгийн “ Selenge.gov.mn ” цахим хуудсанд цаг үеийн шуурхай мэдээллүүдийг байршуулж олон нийтэд мэдээлж ажилласан. Нутгийн захиргааны байгууллагуудын төрийн	100

		захиргааны 14 байгууллагын 32 сул орон тоог аайгууллага, албан тушаал, түүнд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг бусад мэдээллийн хамт Selenge.mn, csc.gov.mn зэрэг цахим хуудсууд, иди иди оооооооо и уууу, и ууууеёёёоо хэрэгслэлээр нийтэд ил, тод зарлан нээлттэй байдлыг хангаж ажилёоёоо.	
Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр			
12	Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг оролцуулах	Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг оролцуулахаар Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх ажлын эхлүүлээд байна.	30
13	Хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хууль, хөтөлбөр сурталчилсан нэвтрүүлэг, ярилцлага зохион байгуулах	Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд тайлант онд төвийн “Зууны мэдээ” сонин, орон нутгийн “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин, “Миний Монгол”, “Таны Сэлэнгэ” КТВ, “Өргөн сэлэнгэ” FM болон телевизийн чиглэлийн 5 чөлөөт уран бүтээлчидтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, аймгийн төсвөөс 17.4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж үйл ажиллагаанд нь гэрээлсэн хөлсийг гүйцэтгэлээр тооцон олгож ажилласан.	100
14	Аж ахуй нэгж, байгууллагуудын удирдлага, ажилтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга зүйд сургах, үр дүнг тооцох	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй 12 аж ахуйн нэгж, байгууллагын дунд Авлигагүй, архигүй, тамхигүй сэдэвт спортын арга хэмжээг 2017 оны 05 дугаар сард зохион байгуулсан.	70
15	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх	Аймгийн Засаг даргаас 2017 онд аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй <i>Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээ, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Улаан загалмайн нийгэмлэг, Эмзэгтэйчүүдийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Барселон олимпын зөвлөл, Уяачдын холбоо, Хөдөлмөр нийгмийн зөвшилт 3 талт салбар хороо,</i>	

		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэлэнгэ аймаг дахь салбар, Ахмадын хороо, Хараагүйчүүдийн холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо зэрэг 12 төрийн бус байгууллагатай тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээг гүйцэтгэх ажил үйлчилгээнд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	
Шударга, хариуцлагатай ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр			
16	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилдог тогтолцоонд бүрэн шилжих	Тайлант онд төрийн албаны төв байгууллагын дүгнэлтээр 5 албан тушаалтан, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг 5 албан тушаалтаны хянуулсан байдлыг үндэслэн албан тушаалд тус тус дэвшүүлэн томилсон.	100
17	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, чөлөөлөх асуудлыг олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	Төрийн албаны хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн талаарх төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний талаарх мэдээлэл авах боломжоор хангах үүднээс аймгийн “Selenge.gov.mn” цахим хуудсанд цаг үеийн шуурхай мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна.	70
18	Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	2017 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын 5 хэлтсийн дарга, 4 ахлах мэргэжилтэнг нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан тус тус дэвшүүлэн томилж ажилласан.	100
19	Төрийн албан хаагчийн ашиг сонирхол, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Өмнө нь батлагдаж мөрдөгдөж байсан “Аймгийн Засаг даргын Тамгын газарт мөрдөх ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм”, “Аймгийн Засаг даргын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн тодотгож зөвлөлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд баримтлах зарчмыг шинээр томъёолж мөрдөх зэрэг арга хэмжээг тайлант онд аваад байна.	70
20	Албан тушаалтанд холбогдох ашиг сонирхол, ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол,	Тайлант онд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын	100

	мэдээллийг хүлээн авах, шалгах, хариуцлага хүлээлгэх, дотоод хяналтыг сайжруулах.	зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг зөрчиж ашиг сонирхлын зөрчил гаргасан нь Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалтаар тогтоогдсон 3 албан тушаалтанд хариуцлага тооцон ажилласан. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилго бүхий “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аян болон хяналт, шалгалтын удирдамжийг аймгийн Засаг даргын 2017 оны А/412 дугаар захирамжаар батлуулан энэ оны 10 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газарт 13, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад 12, нийт 25 ёс зүйн хороо шинээр томилогдон ажиллаж байна. 2017 оны 10 дугаар сарын байдлаар АЗДТГ-ын болон 5 сумын ЗДТГ, 11 агентлагийн нийт 34 төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлийн арга хэмжээ авч ажиллаж байна.	
21	Төрийн албаны стандартын хэрэгжилтийг хангах талаар олон талт ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох	Аймгийн хэмжээний “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн сургалтын хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай сургалтыг ажлын байран дээр нь зохион байгуулах замаар орон нутгийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах ажил арга хэмжээг нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад зохион байгуулахад бодлого зохицуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа.	70
22	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын талаарх мэдээлэл авах боломжоор хангах үүднээс аймгийн “ Selenge.gov.mn ” цахим хуудсанд мэдээллүүдийг байршуулан ажиллаж байна.	70
23	Хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заагдсан хариуцлага хүлээлгэх	2017 онд хууль бус шийдвэр гараагүй.	-
24	Тухайн жилийн төсвийн хөрөнгө оруулалт, зарцуулалтыг олон нийтэд мэдээлэх	Аймгийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн мэдээг www.selenge.gov.mn болон холбогдох байгууллагуудын мэдээлэлд сар бүр оруулж олон нийтэд ил тод мэдээлж	70

		байна. Мөн аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ил тод байдлын самбарт хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлийн мэдээг гаргаж олон нийтэд хүргэж ажиллаж байна. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сан, сумдын орон хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг Орон нутгийн хөгжийн сангийн програмд шивж олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллаж байна.	
25	Аймгийн Засаг дарга, Тамгын газраас гаргаж буй шийдвэрийн ил тод байдлыг хангах	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын тогтоол, захирамж, тушаалыг тухай бүр аймгийн албан ёсны цахим хуудасны “Хууль эрх зүй” цэсний Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, “Ил тод байдал” цэсний Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт дотор байршуулж иргэд, олон нийтэд мэдээлж ажилласан.	70
26	Төрийн албан хаагчдын ХАСХОМ-ийн бүрдүүлэлт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах, зөвлөмж боловсруулан сум, агентлагт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	2017-01-05-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан” онлайн сургалтанд хамрагдсан. Аймгийн Татварын хэлтэс, Прокурорын газар, Цагдаагийн газар, Ерөө, Сайхан, Жавхланта сумдын нийт ХАСХОМ гаргагч албан тушаалтнуудад ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн цахим системийн шинэчлэл, мэдүүлэг хэрхэн гаргах тухай сэдвүүдээр сургалт хийсэн. Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар бүртгэж, бүрдүүлэлтийн программд шивж оруулсан. Нийт 221 албан тушаалтан хугацаандаа хөрөнгө орлогын мэдүүлгээ мэдүүлсэн. Орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа 7 ТББ-ын удирдах албан тушаалтны мэдүүлгийг бүртгэж ажилласан. Хугацаа хоцроосон буюу мэдүүлэг гаргахаас татгалзсан мэдүүлэгч гараагүй.	100
Хөндлөнгийн хяналтыг сайжруулах			
27	Авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дэргэд “Иргэний хяналтын зөвлөл”-ийг байгуулан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.15 дахь зорилт, аймгийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.2.6 дахь заалтуудын хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Гэмт	70

		хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд байгуулагдсан “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийн гишүүдэд Авлигатай тэмцэх газартай хамтран сургалтанд хамруулан, чадавхижуулах ажлыг зохион байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байна.	
28	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих боломжийг бүрдүүлэх	Аймгийн Засаг даргаас 2017 онд аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй <i>Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээ, Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг, Улаан загалмайн нийгэмлэг, Эмэгтэйчүүдийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Барселон олимпын зөвлөл, Уяачдын холбоо, Хөдөлмөр нийгмийн зөвшилт 3 талт салбар хороо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Сэлэнгэ аймаг дахь салбар, Ахмадын хороо, Хараагүйчүүдийн холбоо, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар хороо</i> зэрэг 12 төрийн бус байгууллагатай тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэх, хамтран ажиллах гэрээг гүйцэтгэх ажил үйлчилгээнд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх болон авлигын эсрэг явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхэд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага ажилтнуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	
29	Хувийн хэвшлийн байгууллагуудын авлигын эсрэг сүлжээний үйл ажиллагааг дэмжих	Авлигаас урьдчилан сэргийлэх Төрийн бус байгууллагын сүлжээнд аймгийн Засаг даргаас хамтран ажиллах гэрээ байгуулан дэмжлэг үзүүлэн ажиллан, тайланг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж, гарсан санал санаачлагуудыг төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.	70

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс